

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 04 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2024-04-30

Баруун-Урт

Хяналт шалгалтын мэдээлэл:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2024 онд дэвшүүлсэн зорилт, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилтэнд хяналт тавьж, тухайн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дүгнэлт өгөх илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Сангийн сайдын баталсан 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 03 тоот удирдамжийн дагуу Бичигт дэх Гаалийн газрын 2022-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд системийн шалгалт хийгдэж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 31960.5 төгрөгийн нөхөн төлбөрийн 1 салбар акт тогтоож, 2 заалттай хугацаатай албан шаардлага өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Талын зам ТӨХК-д хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 9911.3 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн 2 салбар акт тогтоож, 5 заалттай хугацаатай албан шаардлага өгч ажиллалаа.

Албаны даргын баталсан 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 05 тоот санхүүгийн хяналтын удирдамжийн дагуу аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийгдэж байна.

Бусад мэдээлэл:

Баруун-Урт сумаас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд хамт олноороо хамрагдаж хуваарьт газрын хог хаягдлыг цэвэрлэж, нэгдсэн хогийн цэгт хог хаягдлыг асгасан. Мөн 7 хоног бүрийн бямба гарагт зохион байгуулагдаж

байгаа “Илүүдэл жингүй, эртэч Сүхбаатарчууд” бүх нийтийн гүйлтэд оролцож байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

НЯГТЛАН БОДОГЧ

Б.УЯНГАНЯМ